



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 10 сарын 24 өдөр

Дугаар А/56

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Иргэний хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны “Төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаа, засаглалыг сайжруулах, шинэчлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 61 дүгээр тогтоолын 1-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Монгол-Кувейтын байгаль хамгаалах төв” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг “Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт нэгтгэхээр шийдвэрлэсэнтэй холбогдуулан эрх, үүрэг, хариуцлага, үл хөдлөх болон бусад эд хөрөнгийг зохих журмын дагуу балансаас балансад орон тооны хамт “Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт шилжүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг 1 дүгээр хавсралтаар байгуулсугай.

2. Ажлын хэсгийн ажиллах удирдамжийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

3. Ажлын хэсэг ажиллахад шаардагдах зардлыг “Монгол-Кувейтын байгаль хамгаалах төв” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын холбогдох эх үүсвэрээс зарцуулсугай.

4. “Монгол-Кувейтын байгаль хамгаалах төв” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын хөрөнгө шилжүүлэх асуудлыг 2025 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулан шийдвэрлүүлэхийг Ажлын хэсэг (В.Дарханбаатар)-т үүрэг болгосугай.


ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

133003798

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
даргын 2025 оны 10 дүгээр сарын 24-ны өдрийн
А/36 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ахлагч

В.Дарханбаатар /Төрийн өмчийн удирдлага,
зохицуулалтын хэлтсийн Удирдлага,
төлөөллийн албаны дарга/

Гишүүд:

Т.Золбаяр /Байгаль орчин, уур амьсгалын
өөрчлөлтийн яамны Төрийн захиргааны
удирдлагын газрын дарга,
зөвшилцсөнөөр/

Д.Дэчин /Байгаль орчин, уур амьсгалын
өөрчлөлтийн яамны Санхүү хөрөнгө
оруулалтын хэлтсийн Төсвийн төлөвлөлт
хариуцсан ахлах мэргэжилтэн,
зөвшилцсөнөөр/

Б.Балдорж /Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын
хэлтсийн мэргэжилтэн/

Б.Билгүтэ /Төрийн өмчийн удирдлага,
зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн/

Ж.Чойханд /"Уур амьсгалийн өөрчлөлтийн судалгаа,
хамтын ажиллагааны төв" төрийн өмчит
үйлдвэрийн газрын захирал,
зөвшилцсөнөөр/

А.Айбек /"Монгол-Кувейтийн байгаль хамгаалах
төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын
захирал/

Ж.Жавзандулам /"Монгол-Кувейтийн байгаль хамгаалах
төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын
нягтлан бодогч/

Нарийн бичиг:

О.Ишханд /Төрийн өмчийн удирдлага,
зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн/

Б.Мөнхбаяр /"Уур амьсгалийн өөрчлөлтийн судалгаа,
хамтын ажиллагааны төв" төрийн өмчит
үйлдвэрийн газрын санхүүгийн ажилтан,
зөвшилцсөнөөр/

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
даргын 2025 оны 10 дүгээр сарын 24-ны өдрийн
4/38 дугаар тушаалын 2 дугаар хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН АЖИЛЛАХ УДИРДАМЖ

Нэг: Зорилго.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 61 дүгээр тогтоолын 1-т заасны дагуу “Монгол-Кувейтын байгаль хамгаалах төв” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг “Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт нэгтгэхээр ажлын хүрээнд Ажлын хэсэг энэхүү удирдамжийг баримтална.

Хоёр: Хийгдэх ажлын чиглэл.

1. Үйлдвэрийн газрын үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгөд тооллого хийж, санхүүгийн тайлантай тулган баталгаажуулалт хийх, акт үйлдэх, хөрөнгө хүлээн авах эрх хүлээн авагчид шилжүүлэх ажлыг зохион байгуулах;

2. Төсвийн болон бусад өр төлбөр, ажиллагсадтай хийх өр, авлагын тооцоог хийж актаар баталгаажуулах;

3. Үйлдвэрийн газрын дуусаагүй худалдан авалт, гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг, судалгаа шинжилгээний бүтээл зэргийн эрхийг холбогдох хууль журмын дагуу хүлээлцэх;

4. Үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийг зохих журмын дагуу балансаас балансад шилжүүлж, эрх бүхий байгууллагаар шийдвэр гаргуулах;

5. Архив, албан хэргийн материалыг акт үйлдэн эрх хүлээн авагчид шилжүүлэн өгөх;

6. Санхүүгийн хаалтын тайлан тэнцэл гаргах;

Гурав: Хугацаа, үр дүн.

Ажлын хэсэг “Монгол-Кувейтын байгаль хамгаалах төв” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг “Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт нэгтгэх ажлыг 2025 оны 4 дүгээр улиралд багтаан шийдвэрлэх.

----- о О о -----